



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ш.ИДЭРБАЯСГАЛАН ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

АДЭЗ.04.00 № 01/338
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын 2022 оны А/67 дугаар захирамжаар Орлого бүрдүүлэлт, өр, авлагыг бууруулах, А/144 дугаартай захирамжаар Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулж, бүртгэлгүй хөрөнгүүдийг бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг бүртгэлээс хасах арга хэмжээг тус тус зохион байгуулж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд аймгийн Засаг даргын хяналтад байгаа байгууллагуудаас Соёл, Эрүүл мэнд, Тусгай зориулалтын шилжүүлгийн нийт 130 байгууллага улсын төсөвт шилжсэнтэй холбоотой 13,889.2 сая төгрөгийн бараа материал, 165,872.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь Ерөнхий сайдтай 2022 онд байгуулсан батламж гэрээний хэрэгжилтийг 85.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.